



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 1/354

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.6 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-ын 8.4.2, 8.7 дахь заалт, Боловсролын сайдын 2025 оны А/273 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн буцалтгүй тусламжаар суралцах суралцагчдын нэрсийг хавсралтаар олгосугай.

2.Энэхүү тушаалын хавсралтад заасан суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, сургуулийн нэхэмжлэхийн дагуу сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг шилжүүлэхийг Боловсролын зээлийн сан (О.Сийлэгмаа), тушаалыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангаж ажиллахыг Гадаад хамтын ажиллагааны газар (Б.Энхбаяр)-т тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т үүрэг болгосугай.

САЙД



П.НАРАНБАЯР



ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРТ
2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР СУРАЛЦАХ СУРАЛЦАГЧДЫН НЭРС

№	Овог	Нэр	Суралцах сургууль	Суралцах мэргэжил	Суралцах жил
1	Баатарчулуун	Энхжин	Macquarie university	Хэвлэл мэдээлэл ба харилцаа холбоо	2 жил
2	Ихбуян	Хашбилэг	University of California Los angeles	Улс төрийн шинжлэх ухаан	2 жил
3	Дэлэгдулам	Сундуйжав	Berklee college of music	Электрон хөгжмийн үйлдвэрлэл ба дизайн	4 жил
4	Нямдорж	Наран-Эрдэнэ	Tsinghua university	Эдийн засаг санхүүгийн менежмент	4 жил